

“СҮҮ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04-р сарын 04-ний өдөр

№ 10

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.4 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.13 дахь хэсэг болон 2022 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 02 сарын 22-ны өдрийн №04, 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах явцад зарим харилцагч, сүү бэлтгэн нийлүүлэгч, ажилтнуудын хувьцааны данс, холбогдох мэдээлэл зөрүүтэй, баримт бичгийн зөрчилтэй байгаа тул тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор тус тогтоолуудын 1 дүгээр хэсэгт заасан 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор эзэмшүүлэх хугацааг 1 сарын хугацаагаар буюу 2022 оны 05 сарын 01-ний өдөр хүртэл сунгаж, №04,05 дугаар тогтоолуудад нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2. Энэхүү тогтоолын дагуу холбогдох ажлыг зохион байгуулах, түүнтэй холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах, төлбөр тооцоог хийхийг Санхүүгийн албаны дарга /Э.Уянга/-д, Гүйцэтгэх захирал /М.Болод/-д тус тус зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГАНБААТАР